

Аюулгүй байдал судлалын хөгжилд “Стратегийн судалгаа” сэтгүүлийн оруулсан хувь нэмэр

Бээжингийн Хандсүрэн *

Доктор (Ph.D), дэд профессор, эрдэмтэн нарийн бичгийн дарга, khandsuren@iss.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
Стратеги судалгааны хүрээлэн

Сэсээрийн Буянхишиг

Доктор (Ph.D), мэргэжилтэн, sbuyankhishig@iss.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
Стратеги судалгааны хүрээлэн

Хураангуй

Стратеги судалгааны хүрээлэнгийн “Стратегийн судалгаа” хэмээх улирал тутмын сэтгүүл нь “Аюулгүй байдал, хөгжлийн асуудлууд” нэрээр анх хэвлэгдсэнээс хойш Монгол Улсад аюулгүй байдал судлалыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсаар ирлээ. Энэхүү сэтгүүл түүхэн он жилүүдийн хугацаанд “Соёмбо”, “Стратеги судлал” нэртэйгээр хэвлэгдэж байсан бөгөөд 2013 оноос эхлэн “Стратегийн судалгаа” нэртэйгээр хэвлэгдэж эхэлсэн.

“Стратегийн судалгаа” сэтгүүлд нийтлэгдэж буй эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, ярилцлагын агуулга, хамрах хүрээ нь жилээс жилд өргөжин хөгжиж, олон улс, бүс нутгийн аюулгүй байдлын орчинд гарч буй өөрчлөлт, улс орнуудын баримталж ирсэн бодлого, стратеги, Монгол Улсын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр авч үзэх чухал талбар болж байна. Дээрх асуудлыг судалгааны үр дүнд үндэслэн эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах нь олон улс, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад манай улсын оролцоог нэмэгдүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах, бодлого, шийдвэр гаргахад судалгааны суурь болох, олон улс, бүс нутгийн болон үндэсний аюулгүй байдлын талаарх мэдээллийг нийтэд түгээж, зөв ойлголт өгөх, тус хүрээлэнгийн үйл ажиллагааг гадаад болон дотоодод сурталчлах, судалгааны мэдээллээ харилцан солилцох хүрээг өргөжүүлж байна.

Эдүгээ тус сэтгүүл нь үндэсний, бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдлын талаар эрдэм шинжилгээ, бодлогын шинжилгээ, судалгааны үр дүнг түгээхэд чухал платформ болжээ.

Түлхүүр үгс: Аюулгүй байдал; хөгжлийн асуудлууд; Соёмбо; Стратеги судлал; Стратегийн судалгаа

* Холбоо барих зохиогч

Судалгааны үндсэн хэсэг

Монгол Улсад ардчилал, зах зээлийн тогтолцоо нэвтэрч, төлөвшиж эхэлсэн 1990-ээд оноос улс төрийн онол, олон улсын харилцаа, үндэсний аюулгүй байдлын асуудлыг шинжлэх ухааны үндэстэй судлах шаардлага үүссэн. Батлан хамгаалах яам (БХЯ)-ны сайдын 1990 оны нэгдүгээр сарын 26-ны өдрийн тушаалаар Монгол Улсын энх тайван, аюулгүй байдлыг олон улсын цэрэг-стратегийн байдалтай холбон судлах зорилго бүхий Стратегийн судалгааны төвийг Цэргийн түүхийн хүрээлэнгийн дэргэд анх байгуулсан (Б.Ширнэн, 2017) байдаг. Тус төвөөс “Аюулгүй байдал, хөгжлийн асуудлууд” мэдээлэл-судалгааны эмхэтгэлийг 1990 оны дөрөвдүгээр сард гаргаснаар улирал тутмын “Стратегийн судалгаа” сэтгүүлийн суурийг тавьжээ.

“Аюулгүй байдал, хөгжлийн асуудлууд” мэдээлэл-судалгааны эмхэтгэл нь гадаадын зарим улс орон улсынхаа аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлогын талаар ямар байр суурь баримталдгийг олон нийтэд мэдээлэх, цэргийн судлаачдын ажилд тус дөхөм үзүүлэх зорилгоор эхний хоёр дугаарыг эрхлэн гаргасан байдаг. Тус эмхэтгэлийн анхны дугаарт дэслэгч генерал Ч.Пүрэвдорж “Стратегийг зөвхөн цэргийн урлагийн онолын хүрээнд авч үзвэл явцуу болно. Орчин үед дэлхийн нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн эрчимтэй хөгжлийн нөлөөгөөр стратегийн тухай ойлголт өргөн утга агуулгатай боллоо. Аливаа улс орны эдийн засаг, цэргийн хүч хэрэгслийн боломжоос шалтгаалан стратегийн агуулга шинэчлэгдэн хөгжиж, стратегийн судалгаа нь улс төрийн бодлогын хүрээнд цэргийн хүчний үүрэг, байр суурийг судлах чиглэл болсон байна” (Ч.Пүрэвдорж, 1990) гэж тодорхойлж байжээ. Мөн хошууч генерал Ч.Самбуу гадаадын улс орнуудын стратегийн судалгааны төвүүдийг харьцуулан судалж, судалгааны үр дүнгээсээ “Бидний судалгаанаас үзвэл стратегийн судалгааны асуудлаар 34 оронд 294 томоохон хүрээлэн түүний дотор зөвхөн Батлан хамгаалах судалгаа дагнасан 30 орчим хүрээлэн ажиллаж байна.” (Ч.Самбуу, 1990) зэрэг бодит тоо баримтыг нийтийн хүртээл болгосон нь стратеги, стратегийн судалгааны төв, хүрээлэнгийн талаар нэгдсэн ойлголтод хүрэх, стратегийн судалгааны төвийг хөгжүүлэх нэг алхам болсон. Тус дугаарт тухайн үед Стратегийн судалгааны төвийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Р.Болд “Улс төрийн стратеги нь эдийн засаг, цэргийн бодлогод тулгуурладаг бол цэргийн стратеги нь эдийн засаг, улс төрийн бодлогод түшиглэдэг нь ойлгомжтой”, “... аюулгүй байдлыг хангахад улс төрийн хэрэгслийг жижиг орон том орноос илүү илүү үр ашигтай, уян хатан ашиглах боломжтой ч байж болох юм.” (Р.Болд, 1990) гэсэн нь цэргийн стратегиас улс төрийн стратегийг салгаж ойлгох, аюулгүй байдлын талаарх ойлголтыг өгөх, аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах асуудлыг хөндсөн хэрэг байлаа. Тухайн үед тодорхойлсон эдгээр тодорхойлолт нь өнөө ч утга төгөлдөр, том гүрнүүдийн хэрэгжүүлж буй бодлого, стратегитай нийцэж байна. Тухайн сэтгүүлд Америк, Финланд, Японы судлаачдын судалгаа, цэргийн номлолыг орчуулан нийтэлж байжээ.

БХЯ-ны сайдын 1991 оны нэгдүгээр сарын 21-ний өдрийн тушаалаар Стратегийн судалгааны төвийг БХЯ-ны дэргэдэх бие даасан судалгааны төв

болгосноор “Аюулгүй байдал, хөгжлийн асуудлууд” мэдээлэл-судалгааны эмхэтгэлийн нэрийг Зэвсэгт хүчний “Соёмбо” болгон өөрчилж, мөн адил хоёр дугаар хэвлэгдсэн байдаг. Тухайн үед Стратегийн судалгааны төвөөс “БНМАУ-ын үндэсний аюулгүй байдлын хангах асуудал” сэдвээр зохион байгуулсан ярилцлагыг “Соёмбо” мэдээлэл-судалгааны эмхэтгэлд бүрэн эхээр нийтэлсэн (Т.Намсрай, 1991) нь аюулгүй байдлыг хангах улс төрийн арга зам, эдийн засгийн болон батлан хамгаалах асуудлууд хэрхэн уялдах талаар хөндсөн төдийгүй нийгэмд зөв ойлголт өгөх улмаар “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Цэргийн номлол” зэрэг бодлогын баримт бичгийн үндэслэлийг боловсруулахад хувь нэмрээ оруулсан гэж үздэг. Мөн Зэвсэгт хүчний цэргийн шинэчлэлийн болон гадаадын зарим улс орны батлан хамгаалах бодлогод гарч буй өөрчлөлтийн талаарх харьцуулсан судалгаа нийтэлж байсан нь ардчилсан нийгэмд шилжсэн манай улсад цэргийн шинэчлэл хийх үндэс суурийг тавихад чухал нөлөөл үзүүлсэн байна.

БХЯ-ны сайдын 1992 оны тавдугаар сарын 01-ний өдрийн тушаалаар Стратегийн судалгааны төвийг Стратегийн судалгааны хүрээлэн болгон өргөтгөн зохион байгуулснаар үйл ажиллагаа өргөжиж, улирал тутмын сэтгүүл гаргах болсон. БХЯ-ны сайдын зөвлөлийн хуралдаанаар тус хүрээлэнгийн дүрмийг батлахдаа “Соёмбо” цэрэг, улс төрийн мэдээллийн тогтмол сэтгүүлтэй байхаар тусгаж, улмаар 1992-1994 онд тус сэтгүүлийн нийт дөрвөн дугаарыг хэвлэн нийтэлжээ. Тус сэтгүүлд геополитик, бүс нутгийн болон үндэсний аюулгүй байдал, аюулгүй байдлын орчин, гадаадын зарим улс орны стратеги, батлан хамгаалах бодлого, цэргийн стратеги, зэвсэгт хүчний өнөөгийн байдлын харьцуулсан судалгааг нийтийн хүртээл болгохын зэрэгцээ Америк, Хятадын судлаачдын судалгааг орчуулж, хэвлэсэн байдаг. Тус сэтгүүлд хэвлэгдсэн “Цэргийн ямар номлол хэрэгтэй вэ?” өгүүлэлд “Хуучны цэргийн номлол хоцрогдож, түүнээс илүү өргөн хүрээтэй төрийн цэргийн бодлогын баримт бичиг шаардлагатай болсон, дэлхий дахинд зэвсэгт хүчнийг энхийг сахиулах, байгалийн гамшигтай тэмцэх, хүрээлэн байгаа орчныг хамгаалахад оролцуулах чиглэлээр өөрчлөн зохион байгуулж, түргэн байрлах, цомхон хүчин болгох хандлага зонхилж байгаа” гэсэн санааг дэлгэрэнгүй өгүүлсэн нь Монгол Улсын Зэвсэгт хүчин олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцож болох юм гэсэн санааг анхлан хөндсөн гэж үздэг. (Р.Болд, 1993).

“Соёмбо” сэтгүүлийг 1993 оны 11 дүгээр сарын 15-нд “Стратеги судлал” эрдэм шинжилгээний сэтгүүл болгон өөрчилж, Хууль зүйн яамнаас улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байдаг. Ингэснээр тус сэтгүүл нь стратеги судлал, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах чиглэлээр дагнан хэвлэгддэг эрдэм шинжилгээний тогтмол хэвлэл болсон байна.

“Стратеги судлал” эрдэм шинжилгээний сэтгүүлийг 1994–2012 онд улирал тутам эрхлэн гаргаж, нийт 55 дугаарыг хэвлэн нийтийн хүртээл болгожээ. Энэ хугацаанд тус сэтгүүлд олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдал, Монгол

Улсын олон тулгуурт гадаад бодлого, гуравдагч хөршийн бодлого, их гүрнүүдийн стратегийн түншлэл, олон улсын байгууллагын хөгжил үүрэг, оролцоо, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, орон нутгийн хамгаалалт, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, түүний хэрэгжилт зэрэг өргөн хүрээний асуудлыг хамарсан эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, ярилцлагыг эмхэтгэн нийтэлж иржээ. Түүнчлэн эдийн засгийн, мэдээллийн, хүний, хүнсний, экологийн, эрчим хүчний аюулгүй байдал, цөмийн хөтөлбөр болон цөмийн зэвсгийн асуудал, энхийг сахиулах ажиллагаа, даяаршил, тогтвортой хөгжил, бүс нутгийн интеграци, гадаадын хөрөнгө оруулалт, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил зэрэг цаг үеийн тулгамдсан асуудлын шийдлийн хувилбар дэвшүүлэх, нийгэмд зөв ойлголт түгээхэд чиглэж байсан нь агуулгын шинжилгээнээс харагдаж байна. Тус сэтгүүлийн нэг онцлог нь гадаад, дотоодын судлаачдын бүтээлийг олон хэлээр нийтэлж байсан явдал юм. Тухайлбал: ОХУ-ын судлаачдын эрдэм шинжилгээний өгүүллийг орос хэлээр, Монголын судлаачдын зарим бүтээлийг англи хэлээр хэвлэн нийтэлж байсан нь олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, судлаачийн судалгааны ажлын үр дүнг олон улсын түвшинд судалгааны эргэлтэд оруулах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж байсныг илтгэх онцлог юм.

“Стратеги судлал” эрдэм шинжилгээний сэтгүүлийг 2013 онд “Стратегийн судалгаа” болгон нэрийг нь өөрчилж, тогтмол эрхлэн гаргах болсон. Өдгөө 100 дахь дугаараа хэвлэн нийтийн хүртээл болгож байна. “Стратегийн судалгаа” сэтгүүлийн агуулга нь өмнөх хугацаанд нийтэлж байсан үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, олон улсын харилцааны асуудлыг үргэлжлүүлэхээс гадна судалгааны чиглэл, хамрах хүрээгээ мэдэгдэхүйц өргөжүүлжээ. Тухайлбал: дэлхийн шинэ дэг журам, төвийг сахих статус, дунд гүрний дипломат ажиллагаа, хоёрдугаар сувгийн дипломат ажиллагаа, жижиг улсын зуучлалын бодлого, тэнцвэржүүлэх стратеги, олон улсын яриа хэлэлцээ, их гүрнүүдийн өрсөлдөөн, хүйтэн дайн, зэвсэгт мөргөлдөөн, нөлөөллийн ажиллагаа зэрэг олон улсын аюулгүй байдлын тулгамдсан асуудлыг хамарсан судалгааны бүтээлийг тогтмол нийтлэгдэх болсон. Үүнээс гадна оршин тогтнохуйн аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, хилийн аюулгүй байдал, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, үндэсний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдал, бүсчилсэн хөгжил, гео-эдийн засаг, эдийн засгийн хамтын ажиллагаа, эдийн засгийн коридор, байгалийн хий дамжуулах хоолой, гадаад өр зэрэг үндэсний хөгжлийн бодлоготой уялдсан асуудлууд мөн судалгааны эргэлтэд орсон байна. Сансрын технологи, кибер орон зай, кибер аюулгүй байдал, кибер дайн, хагас дамжуулагч, хиймэл оюун зэрэг дэвшилтэт технологийн асуудлыг хамарсан судалгааны өгүүллийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж, сэтгүүлийн агуулга, судалгааны хүрээ улам бүр өргөжжээ. Энэ нь тус сэтгүүл үндэсний болон олон улсын аюулгүй байдлын орчинд гарч буй өөрчлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусган, цаг үеийн хэрэгцээнд нийцүүлэн хөгжиж ирснийг илтгэж байна. Энэ хугацаанд тус сэтгүүл нь үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, олон улсын харилцааны чиглэлээрх эрдэм

судлалын ажлыг түгээн дэлгэрүүлэх, бодлогын хэлэлцүүлгийг хөгжүүлэх чухал индэр болж иржээ.

“Стратегийн судалгаа” сэтгүүлийн эрдэм шинжилгээний өгүүллийн агуулга, тоо, эзлэх жинг авч үзье (Хүснэгт 1).

Хүснэгт 1. “Стратегийн судалгаа” сэтгүүлийн эрдэм шинжилгээний өгүүллийн агуулга, тоо, эзлэх жин (1990-2026 он)

№	Эрдэм шинжилгээний өгүүллийн агуулга	Эрдэм шинжилгээний өгүүллийн тоо	Эзлэх жин (хувиар)
1	Олон улсын аюулгүй байдал	230	14.7
2	Бүс нутгийн аюулгүй байдал	126	8.0
3	Орос судлал	52	3.3
4	Хятад судлал	97	6.2
5	Үндэсний аюулгүй байдал	453	28.9
6	Хөгжлийн бодлого	54	3.4
7	Батлан хамгаалах бодлого	137	8.7
8	Онол, арга зүй	60	3.8
9	Үзэл бодол	78	5.0
10	Гадаад хэвлэлд	13	0.8
11	Гадаадын судлаачдын өгүүлэл, орчуулга	87	5.6
12	Түүхийн сургамж	13	0.8
13	Уулзалт, ярилцлага	47	3.0
14	Лавлах материал	121	7.7
Нийт дүн		1568	100.0

Энэ хугацаанд тус сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, үзэл бодол, түүхийн сургамж, уулзалт, ярилцлага, лавлах материал зэрэг нийт 1568 бүтээл хэвлэгдсэн бөгөөд үүнээс үндэсний аюулгүй байдлыг хөндсөн судалгааны бүтээл 28.9 хувийг эзэлж байгаа нь тус сэтгүүл үндэсний аюулгүй байдлын судалгааг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж ирснийг илтгэж байна.

“Стратегийн судалгаа” сэтгүүл 30 гаруй жилийн турш тасралтгүй хэвлэгдэн гарч буй нь түүний шинжлэх ухааны орон зайд эзлэх байр суурийг бататгасан нотолгоо юм (Д.Дорж, 2014) гэсэн нь тус сэтгүүлийн үнэ цэнийг баталгаажуулж байна.

Судалгааны Зөвлөл: Хүрээлэнгийн удирдлага сэтгүүлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд байнга анхаарч, олон төрлийн арга хэмжээ авч байсны нэгийг онцгойлон тэмдэглэх ёстой. 1992 онд Хүрээлэн байгуулагдсан даруйдаа төр засгийн байгууллага, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын байгууллагын төлөөллийг хамруулсан Судалгааны Зөвлөл байгуулсан нь аюулгүй байдлын судалгааг бодлого чиглэлтэй хөгжүүлж, судалгааны үр дүн, мэдээллийг сэтгүүлээр дамжуулан түгээхэд чухал түлхэц, хувь нэмэр оруулсан гэж үзэж байна. Уг Зөвлөлийн бүрэлдэхүүнд дэд эрдэмтэн Ж.Баясах (ОУХДС-ийн захирал), Ч.Ганболд (ЭТНБХ-ны Ерөнхийлөгч), Д.Гэрэл (“Солонго” компаний захирал), дэд эрдэмтэн Я.Долгоржав (ТНСА-ийн ректор), Б.Дашцэрэн (МСХ-ны нарийн бичгийн дарга), бэлтгэл дэслэгч генерал Л.Моломжамц (тус хүрээлэнгийн зөвлөх), дэд эрдэмтэн Г.Төмөрчулуун (ГХЯ-ны газрын зөвлөх), бэлтгэл дэслэгч генерал Ч.Пүрэвдорж (ЦЭШХ-ийн ажилтан), хошууч генерал Б.Шагдар (ЗХЕШ-ын газрын дарга), дэд эрдэмтэн М.Энхсайхан (УИХ-ын гишүүн), дэд эрдэмтэн Ж.Энхсайхан (Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх), дэд эрдэмтэн, хурандаа Б.Эрдэнэбат (ОХУ-ын БХЯ-ны ХТА-ийн докторант) нар (А.Түвшинтөгс, 2022) ажиллаж байсан байна.

Сэтгүүлийн зөвлөл: Батлан хамгаалах яамны сайдын зөвлөлийн 1992 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Соёмбо” сэтгүүлийг цэрэг, улс төрийн мэдээллийн тогтмол сэтгүүл болгож, сэтгүүлийн зөвлөлийг анх байгуулжээ (А.Түвшинтөгс, 2022). Түүнээс хойш сэтгүүлийн зөвлөлөөр ажилласан эрдэмтдийн судалгааг хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. “Стратеги судлал” сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүн (1990-2026 он)


Эрхлэгч	Он	Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн	Нарийн бичгийн дарга/ зохицуулагч	Ерөнхий редактор/ Техник редактор
“Соёмбо” сэтгүүл				
Р.Болд	1991-1992	Х.Аюурзана, Ж.Баясах, Ц.Жаргалсайхан, Ч.Магсар, Д.Мягмар, А.Сүхбаатар, Ц.Тогоо, Ч.Цэрэндагва	Б.Чинбат	
“Стратеги судлал” сэтгүүл				
Р.Болд	1995	Ч.Алтангэрэл, С.Баяр, Ж.Баясах, Р.Болд, Р.Гаваа, И.Каяахара, Л.Моломжамц, Ж.Энхсайхан	Ч.Алтангэрэл	Д.Баясгалан
С.Баяр	1996-1997	Ч.Алтангэрэл, С.Баяр, Д.Баярхүү, Р.Болд, Р.Гаваа, И.Каяахара, Л.Моломжамц, Ж.Энхсайхан	Ч.Алтангэрэл	Д.Баясгалан
	1997	С.Баяр, Ж.Баясах, Р.Болд, И.Каяахара, Л.Моломжамц, Ц.Тогоо, Ж.Энхсайхан	Ц.Тогоо	Т.Одгэрэл

Р.Болд	1997	С.Баяр, Ж.Баясах, Р.Болд, И.Каяхара, Л.Моломжамц, Ц.Тогоо, Ж.Энхсайхан	Ц.Тогоо	Т.Одгэрэл
Л.Моломжамц	1997-2005	С.Баяр, А.Баярмагнай, Ж.Баясах, Р.Болд, И.Каяхара, Л.Моломжамц, Ж.Энхсайхан	А.Баярмагнай 1997-1999 Т.Одгэрэл 1999-2005	Т.Одгэрэл 1997-1999 Д.Азжаргал 1999-2005
Л.Моломжамц	2005	Ж.Базарсүрэн, Ц.Батбаяр, Р.Болд, Ц.Дашзэвэг, Л.Моломжамц		
Д.Мягмар	2006	Р.Болд, Л.Моломжамц, Д.Мөнх-Очир, А.Түвшинтөгс, Б.Энхжаргал	Ч.Болдбаатар	
Д.Мягмар	2007-2009	Р.Болд, А.Түвшинтөгс, Л.Моломжамц, Б.Энхжаргал, Д.Мөнх-Очир, Ж.Энхсайхан, Т.Баярмагнай, Р.Батмэнд,	С.Буянхишиг	
Б.Даваадорж	2009-2010	Р.Батмэнд, С.Галсанжамц, О.Машбат, Ж.Мэндээ, Ц.Бумхорол, Б.Индра, Д.Мөнх-Очир, Б.Хурц, П.Хосбаяр, М.Батчимэг, Д.Мягмар	С.Буянхишиг	Р.Батмэнд, Б.Ундраа, О.Машбат
Д.Ганбат	2010-2013	М.Батчимэг, О.Машбат, Д.Мягмар, Б.Индра, Л.Моломжамц, Д.Мөнх-Очир	С.Буянхишиг	Р.Батмэнд, О.Машбат, Ч.Чулуунбаатар,
“Стратегийн судалгаа” сэтгүүл				
Д.Ганбат	2013-2017	М.Батчимэг, О.Машбат, Д.Мягмар, Б.Индра, Л.Моломжамц, Д.Мөнх-Очир	С.Буянхишиг	Р.Батмэнд, О.Машбат, Ч.Чулуунбаатар,
		М.Батчимэг, Л.Моломжамц, Д.Мөнх-Очир, Р.Болд, Ш.Алтангэрэл, О.Машбат, Б.Эрдэнэбат, Д.Мөнхтөр, Ш.Батсүх, В.Данаасүрэн, М.Одбаяр, М.Алтанбагана, Г.Базарваань, Б.Ариунзул,	Н.Сарантуяа, Б.Цэцэгсайхан, З.Болор, Э.Жаргал, Г.Уранбайгаль, Д.Мөнхтөр, Б.Ариунзул, Ч.Оргил, О.Энхболд, Д.Төмөрпүрэв	С.Буянхишиг
Б.Энхбайгаль	2017-2019	Ж.Батсуурь, Г.Базарваань, Д.Батмөнх, Э.Энхмаа	Д.Мөнхтөр	
Б.Баттөр	2020	А.Түвшинтөгс, Э.Энхмаа, Б.Отгонсүрэн, Ч.Цэцэгмаа, Я.Баасанбат (ҮАБЗ), Ц.Амар (ҮАБЗ)	С.Буянхишиг	А.Түвшинтөгс
Б.Баттөр	2020	Э.Энхмаа, Б.Отгонсүрэн, Ч.Цэцэгмаа	С.Буянхишиг	

Б.Даваадорж	2021-2023	З.Болдбаатар, Э.Энхмаа, Б.Отгонсүрэн, Ч.Цэцэгмаа, А.Түвшинтөгс, Н.Энхбаяр, Ц.Минжин, Н.Соёлгэрэл, Б.Содбилэг, П.Батжаргал	С.Буянхишиг	Ж.Мэндээ
Ж.Мэндээ	2024-2025	Ц.Минжин, Н.Соёлгэрэл, П.Батжаргал, Б.Содбилэг,	С.Буянхишиг	Б.Хандсүрэн
Ж.Мэндээ	2025-2026	Р.Болд, Г.Нарангэрэл, Н.Соёлгэрэл, П.Батжаргал, Б.Содбилэг, Э.Энхмаа, Ц.Гандорж, Д.Буяндэлгэр	С.Буянхишиг	Б.Хандсүрэн
О.Машбат	2026	Р.Болд, Г.Нарангэрэл, Н.Соёлгэрэл, П.Батжаргал, Б.Содбилэг, Э.Энхмаа, Ц.Гандорж, Д.Буяндэлгэр	С.Буянхишиг	Б.Хандсүрэн

“Стратегийн судалгаа” сэтгүүл нь 2025 онд Journal Publishing Practices and Standards (JPPS)-ын үнэлгээний шалгуурт хамрагдаж, нэг одны түвшний шаардлагыг хангасан нь тус сэтгүүлийн редакцын үйл ажиллагаа, хянан магадлаганы тогтолцоо, хэвлэн нийтлэх зарчим, нийтлэлийн чанарын шаардлагыг хангаж байгааг илэрхийлж байна. Тус сэтгүүл нь олон улсын эрдэм шинжилгээний хэвлэлийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд нэвтрэх зорилгоор DOI (Digital Object Identifier) дугаар олгох системийг нэвтрүүлж, нийтлэгдсэн бүтээлүүдээ олон улсын стандартын дагуу бүртгэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ энэхүү цахим шинэчлэлийн хүрээнд сэтгүүлээ MongoliaJOL (<https://www.mongoliajol.info/index.php/MJSS>) платформд байршуулсан. Цахим платформд нэгдсэнээр судалгааны бүтээл нээлттэй, системтэй түгээгдэж, бүтээлийг хайх, ашиглах, эш татах боломж нэмэгдэн, сэтгүүлийн мэдлэг түгээх чиг үүрэг өргөжиж байна.

Зураг 1. “Стратегийн судалгаа” сэтгүүлийн цахим хандалтын харьцуулсан судалгаа



Эх сурвалж: <https://www.mongoliajol.info/index.php/MJSS>

“Стратегийн судалгаа” сэтгүүлд хэвлэгдсэн судалгааны бүтээлүүдийн хандалтын статистикаас харвал 2025 оны 10 дугаар сараас 2026 оны зургаадугаар сар хүртэлх хугацаанд тогтвортой өсөлттэй байгаа нь сэтгүүлийн цахим хүртээмж сайжирч, нийтлэгдсэн бүтээлүүдийн судалгааны эргэлтийн хэрэглээ нэмэгдэж байгааг илэрхийлэх нэгэн чухал үзүүлэлт юм. “Стратегийн судалгаа” сэтгүүлийг цахим орчинд байршуулсан эхний сард хандалтын тоо 300 орчим байсан байсан бол 2026 оны зургаадугаар сарын байдлаар хандалтын тоо 3604 болж, анхны үзүүлэлтээс ойролцоогоор 13 дахин өссөн нь сэтгүүлийн олон улсад өрсөлдөх боломжийг нэмэгдүүлж байна.

“Стратегийн судалгаа” сэтгүүлээс улбаалан БХЭШХ-гийн “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал”, ҮТИС-ийн “Тусгаар тогтнол” сэтгүүл, Геополитик судлалын хүрээлэнгийн “Геополитик судлал” бүтээлийн эмхэтгэл, мөн аюулгүй байдал судлалын төрөл бүрийн тогтмол судалгаа зэрэг хэвлэмэл бүтээгдэхүүн тогтмол гаргаж байгаа нь “Аюулгүй байдал судлал” Монгол Улсад өргөжин хөгжиж байгаагийн баталгаа гэж үзэж болно (А.Түвшинтөгс, 2022) хэмээсэнтэй санал нэгдэж байна. Түүнчлэн батлан хамгаалах, аюулгүй байдал, хууль сахиулахуй, дотоод хэргийн чиглэлийн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлөөс тус сэтгүүлд хэвлэгдсэн бүтээлийг мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэнд тооцож байгаа нь судлаачдын эрдмийн зэрэг хамгаалах үйл ажиллагаанд чухал дэмжлэг үзүүлж байна. Энэ утгаараа тус сэтгүүл нь зөвхөн судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх хэвлэл төдийгүй аюулгүй байдал судлалын хүний нөөцийг бэлтгэх, эрдэм шинжилгээний залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээний судалгааны орчныг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн академик индэр юм.

Дүгнэлт

“Стратегийн судалгаа” сэтгүүлийг улирал тутам эрхлэн аюулгүй байдал, олон улсын харилцаа, батлан хамгаалах салбарт ажиллаж буй эрдэмтэн, судлаач, мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээний өгүүллийг хэвлэн нийтэлж, шинжлэх ухааны мэдлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ шинэ үеийн судлаачдыг бэлтгэх, стратегийн асуудлыг онол, практикийн уялдаатай судлах академик орчныг бүрдүүлж байна.

“Стратегийн судалгаа” сэтгүүл нь Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Нийгмийн шинжлэх ухааны салбарын бага чуулганы салбараас нэр дэвшиж, дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалтад багтсан нь тус сэтгүүлийн эрдэм шинжилгээний чанар, редакцын бодлого, нийтлэлийн шаардлага тодорхой түвшинд хүрснийг илэрхийлэх үзүүлэлт юм. Мөн олон улсын түвшинд хүрсэн нь судалгааны үр дүнгээ олон улсад түгээх, мэдээлэл солилцох, улмаар өрсөлдөх өргөн боломжийг олгож байгаагаараа онцлогтой.

Стратеги судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Стратегийн судалгаа” эрдэм шинжилгээний сэтгүүл нь Монгол Улсад аюулгүй байдал судлалын

шинжлэх ухааны хөгжлийн үндэс суурийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан гэж үзэж болно. Тухайлбал: Сэтгүүлд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, үзэл бодол, түүхийн сургамж, уулзалт, ярилцлага, лавлах материал нь ҮБХИС, ДХИС, ҮТИС, БХЭШХ зэрэг сургалт, судалгааны байгууллагын аюулгүй байдлын чиглэлээр суралцаж буй доктор, магистрын түвшний сургалт, эрдэм шинжилгээний ажлын чухал эх сурвалж болж ашиглагдаж байна. Үүний зэрэгцээ аюулгүй байдлын чиглэлээр ажиллаж буй эрдэмтэн, судлаач, докторант, магистрантуудын судалгааны үр дүнг нийтэлж, судалгааны эргэлтэд оруулахад бодит хувь нэмэр оруулсан. Тус сэтгүүл нь зөвхөн эрдэм шинжилгээний бүтээл хэвлэн нийтлэх хэрэгсэл бус, стратегийн судалгааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, бодлого боловсруулагчид болон судлаачдын хамтын ажиллагааг дэмжих, Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогын судалгааны хөгжлийг урагшлуулах институцийн чухал платформ болон төлөвшиж байна.

Эх сурвалжийн жагсаалт

- А.Түвшинтөгс. (2022). Монгол Улсад аюулгүй байдал судлал үүсэж, хөгжихөд “Стратеги судлал” сэтгүүлийн гүйцэтгэсэн үүрэг (1990-2006). Үндэсний аюулгүй байдал-30 (р. 77). Улаанбаатар: Стратеги судалгааны хүрээлэн;
- Б.Ширнэн. (2017). Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын төлөө 25 жил. Улаанбаатар: Мөнхийн үсэг;
- Д.Дорж. (2014). Үндэсний аюулгүй байдлын шинэ сорилт ба Монгол Улс. Стратегийн судлал сэтгүүл, №3, 45-47;
- Р.Болд. (1990). Аюулгүй бодлого, зэвсэгт хүчин, орчин үе. Аюулгүй байдал, хөгжлийн асуудлууд, №1, 15-16;
- Р.Болд. (1993). Цэргийн номлол ямар хэрэгтэй вэ? Соёмбо;
- Стратегийн судалгааны хүрээлэнд. (1992). Аюулгүй байдал, хөгжлийн асуудлууд, 104х;
- Т.Намсрай. (1991). Практик ажлаа ч нэгтгэх болжээ. Соёмбо, №5, 7;
- Ч.Пүрэвдорж. (1990). Стратегийн судалгааг хөгжүүлье. Аюулгүй байдал, хөгжлийн асуудлууд, №1, т. 4-5;
- Ч.Самбуу. (1990). Гадаадын орнууд дахь стратегийн судалгааны төвүүд. Аюулгүй байдал, хөгжлийн асуудлууд, №1, 8;
- Мөн Аюулгүй байдал, хөгжлийн асуудлууд; Соёмбо; Стратеги судлал; Стратегийн судалгаа сэтгүүлийн бүх дугаарт түүвэр хийж, ашигласан.

Contribution of the “Strategic studies” journal to the development of security studies

Khandsuren Beejin *

Doctor (Ph.D), Associate professor, Dean of Research, khandsuren@iss.gov.mn
The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Buyankhishig Seseer

Doctor (Ph.D), specialist, sbuyankhishig@iss.gov.mn
The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Abstract

Since its inception, the quarterly journal of the Institute of Strategic Studies, “Security and Development Issues”, has made a valuable contribution to the development of security studies in Mongolia. Over the years, the journal has been published under the titles “Soyombo” and “Strategic Studies” and has been published since 2013 under the title “Strategic Studies”.

The content and scope of academic papers and interviews published in the journal “Strategic Studies” has expanded from year to year and has become an important platform for scientifically grounded research and publications regarding changes in the international and regional security environment, the policies and strategies of the foreign countries, national security issues and foreign policy of Mongolia. Incorporating research-based findings on these issues into academic circulation has enhanced Mongolia’s participation in ensuring international and regional security, served as a research foundation for national security policy and decision-making, disseminated information on international, regional, and national security to the public, fostering accurate understanding, promoted the Institute’s activities both domestically and internationally, and expanded the scope of mutual research exchange.

The “Strategic Studies” journal has become an important platform for disseminating academic publications, policy analysis, and research results on national, regional, and international security.

Keywords: Security and development issues; Soyombo; Strategic Studies; Mongolian journal of Strategic Studies

Received: June 24, 2026 | Accepted: June 30, 2026 | Published online: July 07, 2026



© The Author(s) 2026

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.

* Corresponding author